



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ШААМАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.05 № ГНАГ-А024/13-ШТА-НА-36
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

Дүгнэлт

Ардчилсан намын Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шаамар сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (.....⁶..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Шаамар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



ӨРХ БҮРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

Эрхэм хүндэт Шаамарчууд аа!

Шаамар сайхан нутгаа хөгжүүлэхийн төлөө сумын Ардчилсан намын хорооноос сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулан сонгогч та бүхэндээ өргөн барьж байна.

Та бид харилцан итгэлцэж хамтран ажиллавал энэхүү мөрийн хөтөлбөр Засгийн газрын бодлого, шийдвэртэй бүрэн уялдаатайгаар хэрэгжиж Шаамарчууд бидний амьдрал, амьдрах орчин нөхцөл дээшилж, нутаг оронд маань бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийг авч ирэх болно.


Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж болох сум, тосгоны нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах замаар төрөөс орон нутгийн иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний нөхцөл хөнгөн шуурхай байдал, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, сумандаа тав тухтай, тогтвор суурьшилтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд ШААМАР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН мөрийн хөтөлбөрийн гол зорилго оршино.

Бид сум, тосгоны эрх ашгийг дээдлэн хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялаг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлж “ШУУД АРДЧИЛАЛ”-ын зарчмаар ажиллах эрхэм зорилгыг дэвшүүлж байна.

Нэг. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ШААМАРЧУУД


- 1.1. Шаамар сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, айл өрхүүдийн ая тухтай амьдрах орчин бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 1.2. “Сайн хашаа” хөтөлбөрийг айл өрхүүдтэй хамтран, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3. Сүү хөргөх цехийг иргэдийн санал, санаачилгаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх талаар хамтарч ажиллана.
- 1.4. Сумын алслагдсан хэсэг болох Манжийн тохой ногооны талбайд цахилгааны дэд станц барьж, байгуулах ажлыг аймгийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулахаар уламжилна.
- 1.5. 1 дүгээр багийн Жимс ногоо хэсгийн төмөр замын урд байрлах өрхүүдэд төмөр замын ард байрлах дэд станцаас 0.4-ийн шугам татаж, цахилгааны шугам сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 1.6. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийт иргэдийн саналын оролцоог хангасан, нээлттэй хяналт тавих боломжтой, бодит бүтээн байгуулалт бий болгохуйц төслийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллана.
- 1.7. Хүнсний ногооны тариалалт, хураалтыг гар аргаар хийдэг байдлыг өөрчилж механикжуулах, автоматжуулах ажлыг Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.8. Гахай, шувуу, зөгий болон бусад туслах аж ахуйг өрх, фермерийн аж ахуйн түвшинд эрхлэхийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.9. Эрчимжсэн мал аж ахуйг мах, сүү, ноос, ноолуурын чиглэлээр төрөлжүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.10. Багийн эмч, багийн Засаг дарга нарын зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллана.
- 1.11. Сумын түүх соёлын дурсгалт газруудыг Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрутад хамруулж, тогтсон хөтөлбөртэй болгоход анхаарч ажиллана.
- 1.12. Цөлжилт, бэлчээрийн доройтлыг бууруулж бэлчээрийн даацад тохирсон мал аж ахуйг эрхлэх бодлого баримтална.
- 1.13. Төмс, хүнсний ногоо, сүү, өндөг, жимс жимсгэнэ, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болсон зөгийн балыг сурталчилж, гадаадад экспортлох боломжийг бүрдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.14. Хүнсний ногоо тариалагчдыг дэмжин тэдний тарьсан ногоонд урамшуулал олгох ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.



- 
- 1.15. Улаанбаатар хотод Шаамарын ногоо, орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны нэгдсэн сүлжээг зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 1.16. Импортоор орж ирэх төмс, хүнсний ногоог хязгаарлаж, зогсоох, төмсийг экспортлох асуудлыг УИХ, Засгийн газарт санал хүргүүлэн шийдвэрлүүлнэ.
- 1.17. Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг тус салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу 5 га хүртэл давуу эрхээр эзэмшүүлэхийг дэмжиж ажиллана.
- 1.18. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг ил тод явуулж, сумын нийт газар эзэмшигч иргэдийн мэдээллийг нээлттэй болгоно.
- 1.19. Сумын хэмжээнд айл өрхүүдийг хүлэмжтэй болгох зорилгоор “Түрээсийн хүлэмж” хөтөлбөрийг үргэлжлүүлэн, 1 жилд 50, 2024-2028 онд нийт 200 ширхэг зуны нийлэг хальсан хүлэмжийг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.
- 1.20. “Ашигтай орлоготой Шаамарчууд” хөтөлбөрийн хүрээнд чанар стандартад нийцсэн өвлийн хүлэмжийг 1 жилд 1, 2024-2028 онд нийт 4 ширхгийг барьж, байгуулах талаар улс, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.21. Чацаргана тариалагчдыг дэмжиж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 1.22. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Нэг жилд нэг зоорь” төсөл хэрэгжүүлж жилдээ 100 тн-ы багтаамжтай нэг зоорь барих ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.
- 1.23. Ойн санг гэрээгээр эзэмшдэг ААН байгууллагуудтай хамтарч ажиллаж, тэдгээрийг төсөл хөтөлбөрт хамруулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.
- 1.24. Охиндий, Их буланд байгаа хадлангийн газар бэлчээрийг хамгаалах, хашаажуулах ажлыг малчидтай хамтран зохион байгуулна.
- 1.25. Малын тоо толгойн татварын хөрөнгөөр эрлийз болон цэвэр үүлдрийн бухыг нутагшуулж, сумын малчин болон мал бүхий иргэдийн малын үүлдэр угсааг үе шаттайгаар сайжруулна.

Хоёр. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ШААМАРЧУУД


- 2.1. Сумын эмнэлгийн үйл ажиллагааг стандартын дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх талаар хамтарч ажиллана.
- 2.2. Дэлгэрхаан, Охиндий, Дулаанхаан багуудад эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усны төвлөрсөн системийг байгуулахад анхаарч ажиллана.

- 
- 2.3. Эрүүл мэндийн төвүүдийн эмч, сувилагч, эмийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоодын ижил төстэй эмнэлгүүдэд жилд нэг удаа давтан сургах дадлагажуулах ажлыг зохион байгуулна.
 - 2.4. Эмнэлгийн яаралтай тусламжийн чанарыг сайжруулж, тусламжийн нэгдсэн сүлжээг бий болгож, алсын дуудлагад эмнэлгийн зориулалтаар бүрэн тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй болгох санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулан шийдвэрлүүлнэ.
 - 2.5. Жилд 2 удаа Охиндий багийн малчдад эмнэлгийн явуулын үзлэг оношилгоог хийлгэж хэвшүүлнэ.
 - 2.6. Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлж, сувиллын тоог нэмэгдүүлнэ.
 - 2.7. Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэргэжлийн нийтийн биеийн тамирын арга зүйч ажиллуулах, нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэх эрүүлжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагуудыг онцгойлон анхаарч, дэмжиж ажиллана.
 - 2.8. Иргэдийг 3 жил тутамд эрүүл мэндийн иж бүрэн оношилгоонд оруулах талаар эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллана.
 - 2.9. Худаг, ундны усны ариун цэврийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
 - 2.10. Айл өрхийн нүхэн жорлонгийн асуудлыг Жорлонгоо өөрчилье ТББ, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтарч шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

Гурав. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ШААМАРЧУУД

- 3.1. Сумын төвийн сургуулийн их засварын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх талаар уламжилна.
- 3.2. Сумын төвийн 1 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг аймгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх талаар уламжилна.
- 3.3. Улс, аймгийн олимпиадад тэргүүн байр эзэлсэн багш сурагчдын бодлогоор дэмжиж, урамшуулах бодлого баримталж ажиллана.
- 3.4. Сумын хэмжээнд аливаа секц, дугуйлан явуулж байгаа багш, дасгалжуулагч нарыг бодлогоор дэмжин ажиллана.
- 3.5. Сумын багш, сурагчдыг гадаад, дотоодын нэр хүндтэй их дээд сургуулиудын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад нь холбогдох яаманд хүсэлт гаргах замаар дэмжлэг үзүүлэн, эргэж сум орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарч ажиллана.
- 3.6. Сумын хүүхэд залуучуудыг англи, орос, хятад хэлний боловсрол олгох сургалтад хамруулах талаар хамтран ажиллана.

- 3.7. Гадаад дотоодын төсөл, хөтөлбөрт хамрагдан, боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сургууль цэцэрлэгийн урсгал болон их засварыг үе шаттайгаар хийж, сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлнэ.
- 3.8. Сумын Соёлын төвийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 3.9. Хөдөлмөрийн зах зээл судалгаанд тулгуурлан, ажлын байрны захиалгын дагуу Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдээр дамжуулан мэргэжилтэй ажилтныг бэлтгэх талаар хамтарч ажиллана.




Дөрөв. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ ШААМАРЧУУД

- 4.1. Төв суурин газруудын гэр хорооллын хаягжилтын шинэчлэлтийг хийнэ.
- 4.2. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож цэвэр орчныг бүрдүүлэх талаар анхаарч ажиллана.
- 4.3. Архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй эрүүл идэвхтэй амьдралын клубийг сумандаа байгуулна.
- 4.4. Малын хулгай гэмт хэрэгтэй тэмцэх ажлын зохих байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.5. Сургуулийн автобус ажиллуулж, хүүхдүүд сургуульдаа аюулгүй ирж буцдаг байх асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллагад уламжлан санхүүжилтийг шийдвэрлүүлнэ.
- 4.6. Сумын 1-р багийн нутаг дэвсгэр 34-р тогц, 2-р багийн нутаг дэвсгэрт эрүүл ахуйн шаардлага хангасан стандартад тэнцсэн хүүхдийн тоглоомын талбайг байгуулах талаар уламжилна.
- 4.7. Сумын төвийн зарим хэсэг болон 34-р тогцт стандартад нийцсэн аюулгүй сайжруулсан зам тавих. Нийт 1 жилд 1 километр сайжруулсан зам, 4 жилд 4 километр замыг сумын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллана.
- 4.8. Айл өрхүүдийг төвлөрсөн дулааны шугамд холбох буюу 1 жилд 200 метр, 4 жилд 800 метр байхаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллана.
- 4.9. Иргэдэд аюулгүй таатай орчин бүрдүүлэх зорилгоор гудамжны гэрэлтүүлгийг 1 жилд 30 шон буюу 1.2 километр, 4 жилд 120 шон буюу 4.8 километр, Дулаанхаан тосгонд 4 жилд 120 шон буюу 4.8 километр, нийт сумын хэмжээнд 9.6 километр газрын гэрэлтүүлгийг аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр уламжилж, шийдвэрлүүлнэ.

Тав. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ ШААМАРЧУУД

- 5.1. Төрөөс ард иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг шинэ шатанд гаргаж, төрийн захиргааны хүнд суртал, улс төржилтийг арилгана.

5.2. Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган ажиллана.



ШААМАР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО